



414 96

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2008 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

БОКСЫН БАГ ТАМИРЧДЫН ЦУГЛАРАЛТ, СЭРГЭЛТ, ХАМТАРСАН БЭЛТГЭЛИЙН ЗАРДЛЫН ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 189 дүгээр тогтоол, "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 18.6, 18.7 дугаар заалт, нийслэлийн Засаг даргын 2007 оны 621, 2008 оны 161 дүгээр захирамжийг тус тус үндэслэн **ТУШААХ НЬ:**

Нэг. ОХУ-ын Буриадын Улаан-Үд хотноо 2008 оны 06 дугаар сарын 18–22-ны өдрүүдэд болох ЗХУ-ын гавъяат тамирчин, Токиогийн Олимпын наадмын финалист, Европын аварга, Европын цомын аварга Великтон Иннокентьевич Баранниковын дурсгалд зориулсан Бүх Оросын "А" зэрэглэлийн "Байкал-2008" тэмцээн, ОХУ-ын Красноярск хотноо 2008 оны 06 дугаар сарын 24–28-ны өдрүүдэд болох Красноярск хотын Хүндэт иргэн, Сибирийн холбооны их сургуулийн Политехникийн дээд сургуулийн анхны ректор В.Н. Борисовын дурсгалд зориулсан Бүх Оросын 10 дахь удаагийн тэмцээнүүдэд Оюутны шигшээ багийн Боксын баг тамирчдыг оролцуулахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Оюутны шигшээ багийн Боксын баг тамирчдын тэмцээнд оролцох, хамтарсан бэлтгэл, цугларалт, сэргэлтэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Оюутны шигшээ багийн Боксын баг тамирчдад шаардагдах 1.500.000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгийг Оюутны шигшээ багийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Ж.Цэдэнсодном/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Оюутны шигшээ багийн Боксын баг тамирчдыг олон улсын тэмцээнд амжилттай оролцуулах, бэлтгэл, цугларалт, сэргэлттэй холбогдсон тооцоог ирснээсээ хойш 7 хоногт багтаан санхүүтэй хийж дуусгахыг Оюутны шигшээ багийн Боксын дасгалжуулагч /Р.Чинбат/-д үүрэг болгосугай.




ДАРГА

Ж.ГАНБОЛД

050090

НБТСХ-ны даргын 2008 оны 06 дугаар сарын
16-ны өдрийн 40 дугаар тушаалын хавсралт



**БОКСЫН БАГ ТАМИРЧДЫН ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ,
ХАМТАРСАН БЭЛТГЭЛ, СЭРГЭЛТИЙН ЗАРДЛЫН
ТӨСӨВ**

№	Зардлын нэр	Нийт үнэ /төг/
1.	УБ – Улаан-Үд – Красноярск Красноярск /унаа/ /300.000 төг х 3 хүн/	900.000
2.	Байр хоолны зардал: /200.000 төг х 3 хүн/	600.000
БҮГД:		1.500.000